Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлд дараах хэсгийг нэмсүгэй:

“8.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан журмыг батална.”

2 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.3.Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой харилцааг журмаар зохицуулна.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг ..... оны .....дугаар сарын .....ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг